



СЕКЮРИТИЗ
ҮЦК

2022.05.30-2022.06.03

ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ



2022.06.06-ны pre-trading session байдлаар

АНУ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
US30	32,989.00	0.27%	-0.69%	2.29%	-4.75%
US500	4,121.03	0.30%	-0.91%	3.24%	-2.51%
NASDAQ	12,599.00	0.40%	-0.65%	3.37%	-8.72%
Европ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
GB100	7,533.00	-0.98%	0.14%	-0.38%	5.98%
DE40	14,460.00	-0.17%	-0.01%	3.50%	-7.86%
FR40	6,485.00	-0.23%	-0.47%	1.40%	-0.47%
IT40	24,167.00	-1.06%	-1.91%	1.11%	-5.49%
ES35	8,725.00	-0.22%	-2.34%	2.64%	-4.00%
Ази	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
JP225	27,834.00	0.26%	1.53%	5.58%	-4.24%
SHANGHAI	3,200.00	0.15%	1.29%	6.17%	-11.39%
CSI 300	4,098.00	0.18%	1.12%	5.08%	-22.80%
SHANGHAI 50	2,780.00	-0.36%	-0.49%	2.59%	-23.22%
CH50	13,514.68	0.00%	2.63%	0.38%	-25.02%
SENSEX	55,769.00	-0.09%	1.61%	0.18%	7.04%
Эрчим хүч	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
Газрын тос (Crude Oil)	119.73	0.72%	2.12%	17.65%	73.42%
Газрын тос (Brent)	120.51	0.66%	2.47%	15.21%	68.57%
Байгалийн хий	8.82	3.58%	1.62%	25.53%	187.30%
Шатахуун	4.29	0.83%	6.19%	21.48%	95.51%
Нүүрс	412.5	0.00%	1.44%	16.20%	239.23%
Түүхий эд	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
Алт	1,853.50	0.15%	-0.15%	-0.02%	-2.40%
Мөнгө	22.25	1.54%	1.37%	2.10%	-20.19%
Зэс	4.43	-1.17%	2.05%	5.57%	-2.43%
Бонд /10 жил/	Өгөөж	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
АНУ	2.94	0.0037	0.13%	-0.09%	1.37%
Англи	2.16	0.0060	0.25%	0.19%	1.37%
Швейцар	1.04	0.0440	0.29%	0.18%	1.17%
Испани	2.44	0.0060	0.40%	0.36%	1.98%
Португали	2.48	0.0650	0.40%	0.35%	2.03%

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээ өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдалд дэмжлэг болж өгч байна

ХНС-аас хэдий инфляцтай тэмцэхээр хатуу мөнгөний бодлого баримталж, эдийн засгийн өсөлтийг бууруулж байгаа ч хөдөлмөрийн зах зээл өөдрөг байна. Өнгөрсөн 7 хоногийн хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой мэдээнээс тоймлож хүргэвэл:

1. Ажилтай хүмүүсийн тоо өсөж байгаа нь өрхийн худалдан авалтад сайнаар нөлөөлнө.

Өнгөрсөн 7 хоногийн мэдээгээр энэ 5 сард 390 мянган шинэ ажлын байр нэмэгдсэн нь шинжээчдийн таамаглаж байсан 322 мянгаас илүү гарчээ. Зочлон үйлчлэх салбар 84 мянган шинэ ажлын байраар зузаатгасан нь хамгийн их өсөлттэй салбар байв. Үүний дараагаар бизнес үйлчилгээ, барилга, үйлдвэрийн салбарууд оржээ.

Зочлох үйлчилгээний салбарт шинэ ажлын байр ихээр нэмэгдэж байгаа нь өрхийн худалдан авалт; бараа бүтээгдэхүүнээс илүүтэйгээр үйлчилгээ рүү шилжиж байгааг харуулж байна. Тус салбар одоо л цар тахлын уналтаас сэргэж эхэлж байна.

390 мянган хүн ажиллах хүчинд нэмэгдэж байгаа нь хүн хүчний хомсдол буурахад нөлөөлөх ба ихэнх ажилчид 25-54 насны хооронд байна. Цалингийн түвшин өсөж, цар тахлын хоригууд зөөлөрч, халамж буурч байгаа нь хөдөлмөр эрхлэлт цаашид өсөхөд нөлөөлнө гэж шинжээчид үзэж байна.

ХНС хэдий мөнгөний хатуу бодлого баримталж, эдийн засгийн өсөлтийг сааруулах төлөвлөгөөтэй байгаа ч ажлын байрны тоо өсөх хандлагатай байгаа нь эдийн засгийн хямрал болохоос сэргийлэх боломжтой. 2022 он гарснаас хойш шинэ ажлын байрны өсөлтийн хурд аль хэдий нь цар тахлын өмнөх буюу 2018 оны үеийн ажлын байрны өсөлтийн хурднаас давсан үзүүлэлттэй байна.

АНУ-ын ажлын байр нэмэгдсэн тоо



2. Ажилгүйдлийн түвшин бага байгаа нь эдийн засгийн хямрал болохгүй байх магадлалыг өсгөж байна

5 сарын ажилгүйдлийн түвшин 3.6%-тай байгаа нь цар тахлаас хойших доод түвшин ба сүүлийн 50 жилийн доод түвшин юм. Ажилгүйдлийн түвшин бага байх нь өрхийн худалдан авалтыг дэмжихээс гадна сүүлийн 50 жилд ажилгүйдлийн түвшин 4%-иас доош ороогүй тохиолдолд эдийн засгийн хямрал болоогүй юм. Доорх хүснэгтээс харахад, 1979 оноос хойш тохиолдсон эдийн засгийн хямралд ажилгүйдлийн түвшин 14%-иас дээш байх үед болжээ. Энэ нь ажилгүйдлийн түвшин өндөр үед ихэвчлэн эдийн засаг хүндрэлд ордог болохыг харуулж байна.

Он жилүүд	1979-1980	1989-1990	2000-2001	2006-2007	2022	Дундаж
Ажилгүйдлийн түвшин	14.8%	15.8%	14.4%	14.2%	3.6%	14.8%
S&P 500 өгөөж	17%	30%	-21.7%	12%	-	9.5%

Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо хөдөлмөрийн зах зээлийн хандлагыг урьдчилж харуулдаг үзүүлэлтүүдийн нэг билээ. Ажилгүйдлийн тэтгэмж авсан хүмүүсийн тоо өнгөрсөн 7 хоногт 200 мянга болж буурсан нь сүүлийн 5 жилийн дунджаас 15% доогуур байгаа нь хөдөлмөрийн зах зээл сайн байгааг илтгэж байна.

АНУ-ын ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо



3. Цалингийн өсөлт ХНСанг бодлогын хүүг өсгөх үндэслэл болж байна.

Дундаж цагийн хөлс өнгөрсөн оны мөн үеэс 5.2% өссөн нь дараах хоёр зүйлийг илтгэж байна. А) Цалингийн түвшин өсөж байгаа нь өрхийн худалдан авалтыг дэмжиж эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлөхөөр байна. Б) Нөгөө талаараа цалингийн өсөлт нь инфляцыг нэмэгдүүлж ХНСанг бодлогын хүүг өсгөхөд нөлөөлж байна.

Одоогоор цалингийн өсөлт оргил үе болох 6%-иас өсөөгүй байгаа ч ХНС бодлогын хүүг өсгөхөд нөлөөлөхгүй ч инфляц дээд цэгээсээ буурч байж магадгүйг илтгэж байна.

АНУ-ын цалингийн өсөлт болоод инфляц /хувиар/



Эдгээр мэдээнүүд хөрөнгийн зах зээлд хэрхэн нөлөөлөх вэ?

Өнгөрсөн Баасан гарагийн ажлын байрны мэдээ хэдий сайн гарсан боловч ХНСанг хатуу мөнгөний бодлого баримтлах арга барилыг дэмжиж өгч байгаа нь хөрөнгийн зах зээлийг унахад нөлөөлсөн.

Эдийн засгийн өсөлт болон компаниудын ашиг өсөх хандлагатай байгаа ч хөрөнгийн зах зээл тогтворгүй байгаа нь ойрын үед хөрөнгийн зах зээлд U-хэлбэртэй сэргэлт болох болов уу гэж шинжээчид харж байна.

Хөрөнгийн зах зээл аль хэдий нь 5 сарын доод ханшнаас 6% өссөн нь богино хугацааны хэлбэлзлээс илүүтэйгээр урт хугацааны зорилгодоо үндэслэж хөрөнгө оруулалт хийх нь чухал болохыг харуулж байна.

Edwardjones-ийн шинжээчдийн зөвлөж байгаагаар зах зээлийн өндөр үнэлгээтэй, өрсөлдөх чадвар сайнтай, санхүүгийн тогтвортой, ашиг нь цаашид өсөх компаниудад хөрөнгө оруулахыг санал болгож байна.

Одоо алтанд хөрөнгө оруулах оновчтой цаг мөн үү?

Энэхүү үнэт металл нь олон мянган жилийн тэртээгээс арилжааны хэрэгсэл байсаар ирсэн түүхтэй. Олон улсын санхүүгийн системд доллар, евро, юань зэрэг валютууд эргэлдэхээс өмнө алт байсан ба биет хөрөнгийн бэлэг тэмдэг болохоос гадна баялгийг тодорхойлж ирсэн.

Одоо ч гэсэн засгийн газар, төв банк болоод бусад санхүүгийн байгууллагууд алтыг олон улсын валютын нөөцдөө хадгалсаар байна. Сүүлийн хэдэн арван жилд улс орнууд алтны нөөцөө зузаатгаж байгаа нь уг үнэт металлын үнэ цэнийг улам өсгөж байна. Хамгийн сүүлд алтаа худалдсан жишээ бол 1999-2001 оны хооронд Английн Вант Улс нийт алтны нөөцийнхөө талыг унц бүрийг 300 долларт зарж байжээ. Түүнээс хойш 20 жилийн дараа алтны ханш 1800 доллар давсан нь тухайн үед алтны үнэ цэнийг дутуу үнэлж, буруу шийдвэр байсныг харуулж байна.

Алт нь дан ганц мөнгөний үүргийг гүйцэтгэхээс гадна гоёл чимэглэлийн болон баялаг үнэгүйдэхээс хамгаалах хэрэгсэл юм. Товчхондоо алтны гол брэнд бол баялаг, эд хөрөнгийн эцсийн илэрхийлэл болоход оршдог.

Алтны бух зах зээл Английн Вант Улс өөрийн алтны нөөцөө зарахад буюу 2000 оноос хойш эхэлсэн ба энэхүү өсөлт нь өнөөг хүртэл үргэлжилсээр байна. Хэдий дэлхий дахинд нэмж алт олборлож байгаа ч алтны үнэ цэнэ жил ирэх бүр өссөөр байна. Үүний шалтгаан нь алтны ханш өсөхөөс илүүтэйгээр фиат мөнгөний үнэ цэнэ унаж байгаатай холбоотой.

Алтны ханш /доллар/



1800 долларын ханш нь алтны хувьд 2021 оны гол түвшин болж байсан.

Алтны фьючерс ханш 2020 оны 8 сард 2,063 доллар хүрснээр шинэ рекорд тогтоож байсан. Түүнээс хойш 1,673 доллар хүртэл унасны дараа сэргэж 1,800 доллар хавьд 2021 оныг дуустал арилжаалагдсан.

2022 оны 3 сард алтны ханш шинэ дээд түвшиндээ хүрсний дараа завсрын хөдөлгөөн хийсэн

ОХУ Украин улс руу дайрахад алтны ханш 2,072 долларт хүрч шинэ рекорд тогтоосон. Түүнээс хойш 2022 оны 5 сарын дунд гэхэд 1,787 доллар хүртэл унасан боловч одоогоор өсөх трендээ хадгалсаар байна.

Алтны ханш унах үед авч байх нь оновчтой үйлдэл байсаар байна

Алт нь олон мянган жилийн турш баялаг, үнэ цэний хуримтлал болсоор ирсэн нь хөрөнгө оруулалтын чухал зэмсэг гэдгийг илтгэж байна. Алт авах бас нэг шалтгаан нь олон улсын төв банкнууд сүүлийн үед алтны нөөцөө зузаатгаж байгаатай холбоотой.

Хамгийн сүүлд Английн Вант Улс өөрийн алтны нөөцөө зарснаас хойш өөр улсын засгийн газар алтны нөөцөө зараагүй. Өнөөгийн алтны ханш 1,840 доллар байгаа нь 2022 оны 3 сарын оргил ханшнаас 232 доллар доогуур байгаа ч 1999 оны үеийн ханшнаас 7 дахин их байгаа нь энэхүү үнэт металлын үнэ цэнээ хадгалдаг үүргийг харуулж байна.

Алтны ханш одоогийнх шиг бага зэргийн уналттай байхад авах 4 шалтгаан:

1. Түүх: Түүхээс харахад алт нь олон мянган жилийн турш арилжааны үүрэг гүйцэтгэхээс гадна баялаг, үнэ цэнийг хуримтлуулах үүрэг гүйцэтгэж иржээ.
2. Инфляц: Засгийн газар, төв банкнууд мөнгөний нийлүүлэлтийг хүссэн хэмжээгээрээ өсгөж болно. Ингэснээр мөнгө үнэгүйдэж хүмүүсийн хуримтлал аажмаар үгүй болно. Харин алтны нийлүүлэлтийг нэмэхийн тулд илүү их олборлохоос өөр аргагүй тул үнэ цэнээ барагтаа алдах боломжгүй.
3. Геополитикийн хямрал: ОХУ-Украины дайн, БНХАУ-ын эрх мэдэл өсөж байгаа зэрэг нь олон улсад хагаралдаан авчирч тэдгээр улс орнуудын мөнгөн тэмдэгтэд нөлөөлж байгаа боловч алт олон улсын санхүүгийн систем гэсэн байр сууриа хадгалсаар байна.
4. Алтны стандарт газар авч байна. Саяхан ОХУ нэг унц алтыг 5,000 рублиэр үнэлж авдаг болсон нь өөрсдийн валютыг алтны үнэ цэнтэй холбож өгснөөр рублийн ханш огцом өссөн. Хэрвээ БНХАУ өөрсдийн юанийг алтны үнэтэй холбох юм бол долларын олон улсын валютын байр суурь суларч эхэлнэ.

Эцэст нь алтны ханш 2021 оны 3 сарын доод ханшнаас сэргэж өсөлтийн трендэд байгаа ба геополитикийн хямрал цаашид өсөх үндэслэл болж өгч байна. Иймд хөрөнгө оруулалтын багцынхаа зарим хэсгийг алтаар бүрдүүлэх нь оновчтой харагдаж байна.